# ХЭНТИЙ АЙМГИЙН
# БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 25 өдөр Дугаар А/103 Бор-Өндөр сум

Орон нутгийн хөгжлийн сангаас
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.4.1 дэх заалт, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3.4.4 дахь заалт, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 16 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бор-Өндөр сумын 4-р багт "Автобусны буудал байгуулах" ажлыг хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулсан "Ханбагана" ХХК-д 50 хувийн санхүүжилт болох 9,950,000 (есөн сая есөн зуун тавин мянга) төгрөгийг олгосугай.

2.Тус ажлын санхүүжилт болох 9,950,000 (есөн сая есөн зуун тавин мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зарцуулахыг Санхүүгийн албаны дарга (Э.Түвшинсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Г.АДЪЯАБИЛЭГТ

D:/bichig hereg/Захирамж.docx